



**“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД
СУМАНД ХЭРЭГЖИХ “ЭРДЭНЭС ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ” ТӨСЛИЙН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР-5435528/

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

П.ШИНЭЦЭЦЭГ

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
САЛБАРЫН ЗАХИРАЛ

Л.ДОРЖСҮРЭН

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА

Б.БАТСАЙХАН

1. ОРШИЛ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, оршин суугчдын эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, түүний сөрөг үр дагавар, түүнээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг тогтоох явдал байдаг.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Эрдэнэс гаалийн хяналтын талбай” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд уг төслийн үйл ажиллагааны үед байгаль орчин, нийгэм, нутгийн иргэдийн эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга талаар хэрэгжүүлж ирсэн арга хэмжээг үнэлэхийн зэрэгцээ цаашид учирч болох нөлөөллийг тодорхойлох, уг сөрөг нөлөөллийг бууруулах, талаар авах арга хэмжээг тогтоох, төсөл хэрэгжүүлэгчид байгаль орчин, орчны тохижилттой холбоотой мэргэжил арга зүйн зөвлөмжүүдийг өгөх үндсэн чиглэлтэйгээр ажилласан.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Эрдэнэс гаалийн хяналтын талбай” төсөлд БОАЖЯ-ны шинжээч “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2 дугаар хэсэгт заасан аргачлалын дагуу ерөнхий үнэлгээ хийсний үндсэн дээр уг төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай гэж үзсэн. Иймд төсөл хэрэгжүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий “Эхмонголын байгаль” ХХК нь уг төслийн 2023 оны 04 сарын 20-ны өдрийн 12/2178 тоот албан тоотоор баталгаажуулан БОАЖЯ-аас гаргасан байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үндэслэн холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг баримтлан боловсруулсан.

Төслийн үйл ажиллагааны үед байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг агаар, хөрс, ургамал зэрэгт нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн ургамлан бүрхэвчийн талхлагдал, хөрсийг бохирдол, элэгдлээс хамгаалах, агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах, хамгаалах зэрэг арга хэмжээний зөвлөмж, арга зүйг Монгол улсын стандарт, норм нормативд заасан шаардлагын дагуу тусгаж өгөв.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн 2021-2025 оны стратеги төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.

Компани ISO 14001:2016 байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээр байгаль орчны асуудлуудыг албан ёсоор тодорхойлж тэдгээрийг шийдвэрлэх шат дараатай алхмуудыг бодлогын баримт бичигт тусгасан. Стандартын хүрээнд тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээг бууруулах, биологийн задралд ордог бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх болон хог хаягдлын дахин боловсруулалтыг сайжруулах замаар байгальд хаях хог хаягдлын хэмжээг бууруулах, хүрээлэн буй орчинд учруулж байгаа сөрөг нөлөөллийг ялангуяа агаар бохирдуулагчийг хянах тогтолцоог олон улсын түвшинд хүргэх, олон талын хэлэлцүүлэгт үндэслэсэн хаалтын бодлогыг бий болгох, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зэрэг гол асуудлуудыг байгаль орчны гол шалгууруудаар тодорхойлсон.

Эдгээр стандарт шаардлага, төлөвлөлт, хариуцлагын хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэв.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Төслийн ерөнхий мэдээлэл

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь нүүрсийг ил талбайд буулгах, ачих аргачлалыг зогсоож, контейнортой нүүрс ачих, буулгах зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг, Цагаан хадад нийт 13.5 га талбайд Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагаа явуулж байна.

2.2 Төслийн зорилго

Цагаан хадны өнөөдрийн байгаа байдлыг сайжруулахад бусад аж ахуй нэгжүүжтэй өрсөлдөх шинэ техник технологи нэвтрүүлэх, ашиглах, хамаарах орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллах, байгаль орчинд анхаарах нөхөн сэргээлт хийх, био технологийг ашиглах, ажилчдын ажиллах орчинг сайжруулах, шинэ боловсон хүчин бэлдэх гол зорилготой.

2.3 Төслийн хүчин чадал

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Гашуун сухайт боомтын Цагаан Хад гаалийн хяналтын бүсэд 13.5 га талбайд нүүрс буулгаж, хадгалж, ачих үйл ажиллагаа явуулахаар төлөвлөн ажиллаж байна. Гаалийн хяналтын талбай нь 500,000 тонн нүүрс хүлээн авах чадалтай бөгөөд жилд 2 сая тонн нүүрс хүлээн авч борлуулах төлөвлөгөөтэй. Нийт хоёр ээлжээр ажиллах 120-н хүнийг ажлын байраар хангана.

“Эрдэнэс” гаалийн хяналтын талбай дараах барилга байгууламжуудаас бүрдэнэ. Үүнд:

- Нүүрс ачиж буулгах талбай – 10 га:
- Ажилчдын амрах хотхон – 2.25 га:
- Оролтын пүү 1ш (20 тонны контейнер):
- Гаралтын пүү 1ш (байр):
- Агуулах – 1ш (20 тонн):
- Харуулын байр – 2ш:
- 40 м урттай пүү – 2 ш:
- Авто граж болон авто засварын төв:

Төслийн талбайн одоогийн байдал:



Зураг 1. Төслийн талбайн одоогийн байршил, орц, гарц



Зураг 2. Тоосжилт бууруулах зорилгоор байгуулсан салхины хаалт


2.4 Төслийн байршил

“Эрдэнэс гаалийн хяналтын талбай” нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутаг дэвсгэр Цагаан хад хэмээх газарт сумын төвөөс зүүн урагш 70км, Гашуун Сухайтын хилийн боомтоос 22 км-т байрлана.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Ханбогд сумын Засаг даргын 2023 оны 01 сарын 18-ны өдрийн А/04 тоот шийдвэрээр 4601001062 тоот нэгж талбарын дугаар бүхий 13.5 га талбайг 15 жил хугацаатай Гаалийн хяналтын талбай зориулалтаар эзэмшихээр эрх авсан.

Хүснэгт № 1. Гаалийн хяналтын бүсийн солбилцол

Цэгийн дугаар	Өргөрөг			Уртраг		
1	42	35	31.63	107	32	12.77
2	42	35	36.9	107	32	6.89
3	42	35	43.24	107	32	20.54
4	42	35	45.44	107	32	25.18
5	42	35	47.48	107	32	29.47
6	42	35	40.44	107	32	36.59
7	42	35	39.83	107	32	35.1
8	42	35	39.49	107	32	34.3
9	42	35	38.27	107	32	30.91
10	42	35	38.5	107	32	30.72
11	42	35	37.4	107	32	26.7
12	42	35	37.09	107	32	23.2
13	42	35	33.55	107	32	16.54



Зураг 3. Гаалийн хяналтын талбайн байршлын зураг

3. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1 Уур амьсгал

Төслийн бүс нутагт жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа урт, агаарын температурын жилийн болон хоногийн хэлбэлзэл ихтэй, хур тунадас нэн ховор хэт хуурай эх газрын эрс тэс уур амьсгалтай.

Нар гийгүүлэлч: Төслийн талбай байгаа нутаг дэвсгэрт жилдээ 3100 орчим цаг нар гийгүүлэх бөгөөд сарын нийлбэр нь нарны өндрөөс хамаарч 12 дугаар сард хамгийн бага - 212 цаг, 6 дугаар сард хамгийн их -310 цаг байна.

Дулаан хүйтний горим: Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж агаарын температур -11.80С, хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын температур 25.70С буюу сарын дунджаар жилийн агаарын температурын зөрүү нь 37.50С байгаа нь харагдана.

Агаарын температурын хоногийн зөрүү нь дунджаар 9.10С байх бөгөөд хавар, намрын улиралд 10.3-11.10С болж ихэснэ. Хамгийн их нь шилжилтийн улиралд 31-330С хүрдэг аж.

Чийгшлийн горим: Энэ бүс нутагт жилдээ 87-162 мм орчим хур тунадас орох бөгөөд хур тунадасны 90 орчим хувь нь жилийн дулаан улиралд буюу 4-9 дүгээр сард орно. Ханбогдын сумын сүүлийн 5 жилийн нийлбэр хур тунадсыг авч үзвэл 74.0-134.9 мм хэлбэлзэлтэй байна.

Төслийн районд жилдээ 25-30 өдөр бороо орно. Төслийн район ихээхэн хуурай уур амьсгалтай. Жилийн дундаж харьцангуй чийгшил 46-52% орчим байх бөгөөд хавар 36-38% болж буурна. Жилдээ 140 орчим өдөр харьцангуй чийгшил 30%-иас доош орж хуурайшдаг.

Салхи шуурганы горим: Төслийн бүс нутаг бол манай орны хамгийн салхидуу газар нутгийн нэг бөгөөд жилийн дундаж салхины хурд 3.8-4.7 м/с, хаврын саруудын салхины дундаж хурд 4.3-5.3 м/с байдаг газар юм.

Төслийн бүс нутагт жилийн дундаж байдлаар баруун, баруун хойд чиглэлийн салхи зонхилно.

Салхины хурдны жилийн явцад хавар, намрын улиралд 2 удаагийн максимум утга, өвөл, зуны улиралд 2 удаа минимум утга ажиглагдах бөгөөд хаврынх нь үндсэн их утга байх агаад чухам агаар, хөрс хамгийн хуурай үе, салхины хүч хамгийн их үе хоёр давхцахаас болж жилд тохиолддог хүчтэй салхитай болон шороон шуургатай өдрийн тооны 60 гаруй хувь нь зөвхөн хаврын 3 сард тохиолдоно.

Энэ бол хаврын улиралд хөрс салхинд хийсэх, хүчтэй шороон шуурга болж алсын бараа муудах явдал заримдаа гамшгийн хэмжээнд хүрдэг гэдгийг харуулна. Шороон шуурганы 30.0-32.6 хувь нь 1.0-3.0 цаг, 28.1-26.8 хувь нь 3.1-6.0 цаг, 10.3-15.9 хувь нь 9.1-9.0 цаг 5.0-6.1 хувь нь 9.1-12.0 цаг 2.3-2.7 хувь нь 12.1-15.0 цаг үргэлжлэх ба явган шороон шуурганы үргэлжлэх хугацааны хувьд үүнтэй ойролцоо давтагдалтай юм. Энэ бүсэд жилдээ 179-318 цаг /үүнээс шороон шуурга 102-115 цаг, 77-203 цаг явган шороон шуурга/ шороо хийсдэг байна /Нацагдорж, Жүгдэр 1992/.

3.2 Агаарын чанар

Төслийн үйл ажиллагааны үед агаарын чанарт үзүүлэх эх үүсвэр нь нүүрсний овоолго, тээвэрлэлт, ачиж буулгах үед үүсэх тоосжилт байна.

3.3 Гадаргын ус

Тухайн бүс нутагт гадаргын усны сүлжээ маш сийрэг бөгөөд үндсэндээ байнгын урсацтай гол горхи байхгүй юм. Энэ шалтгаанаар ажиглалт хэмжилтийн цуваа бүхий гадаргын усны горим, нөөцийн ажиглалт хэмжилтийн цэг харуул энэ бүс нутагт байхгүй болно. Энэ бүс нутагт гол, сайрын урсац нь хаврын шар ус болон зуны хур борооны үерийн уснаас голчлон бүрдэх бөгөөд тэдгээрийн хэмжээ нь уур амьсгал, газрын гадаргуугийн байдал, тэжээгдэл зэргээс шалтгаална. Зуны улиралд богино хугацаанд орсон эрчимтэй аадар борооны улмаас дээр дурдсан уул болон тэдгээрийн салбар уулсаас эх авах гол,

сайруудад шар ус, хур борооны үер, уруйн үер үүсдэг. Энэ нь улмаар хөрсийг элэгдүүлэн барилга байгууламж эвдэрч нурах зэргээр багагүй хохирол учрахад хүргэж болзошгүй.

3.4 Газрын доорх ус

Бүс нутагт 1970-2000 онд Таван толгойн нүүрсний орд, Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо зэрэг сумдын төвийн усан хангамжийн эх үүсвэрийг олж тогтоох зорилгоор ихээхэн хэмжээний гидрогеологийн эрэл, хайгуул, зураглалын ажил улсын хөрөнгөөр хийгдэж, Балгасын-Улаан нуур, Зайрмагтай, Ханбогд, Баян-Овоо, Үйзэн, Дух толгой гэсэн газрын доорх усны орд газруудыг илрүүлэн, усны ашиглалтын нөөцийг нь тогтоосон байдаг.

Харин 2000 оноос хойш энэхүү бүс нутагт гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд өөрсдийн хөрөнгөөр газрын доорх усны эрэл, хайгуулын ажлуудыг томоохон хэмжээний талбайнуудад хийж, хэд хэдэн газарт газрын доорх усны ордыг олж тогтоогоод, заримыг нь ашиглаж эхлээд байна.

Тухайлбал, “Оюу Толгой” ХХК уурхайд ашиглах усны нөөцийн хайгуулыг 2003-2007 онд хийжээ. Уг судалгааны үр дүнд гаалийн хяналтын талбайгаас хойд зүгт 40-70 км зайд байрлах Гүний хоолойн усны нөөцийг илрүүлсэн байна. Газрын гадаргаас 150-400 метрийн гүнд байрлах энэхүү дарагдмал ус чанарын хувьд ихээхэн эрдэсжилттэй, хайрга, элс, хөрзөн чулуулгийн завсарт байрладаг онцлогтой. Хүмүүс үүнийг булгийн цэвэр ус мэтээр эндүүрдэг. Бас ундны усны шаардлага хангахгүй, ахуйн хэрэглээнд тохиромжгүйг тогтоожээ. Энэ усыг цэвэршүүлэхгүйгээр зөвхөн үйлдвэрт ашиглах боломжтой.

Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2008 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар Гүний хоолойн газрын доорх усны ордыг гидродинамикийн болон балансын аргаар үйлдвэрлэлийн зэрэглэлээр үнэлсэн нөөцийг хүлээж авах тухай дүгнэлт гаргажээ. Гүний хоолойг 6 тэрбум найман зуун сая шоо метр (6,800,000,000) усны нөөцтэй хэмээн тогтоосон байдаг.

Говийн гар худгууд 5-15 метрийн гүнтэй байдаг бол Гүний хоолойн ордын ус нь 70-400 метрийн гүнд байна. Энэ хоёрын хооронд 250 метр хүртэл зузаан шаврын үе бий. Малчдын гар худгууд уул толгодоос усаа цуглуулдаг хуурай сайр, голын голдирол дагасан, хур тунадаснаас хамааралтай гэж үздэг. Тиймээс худгийн усны түвшин хур тунадас болон орчмын айлуудын малын тоо толгойноос хамаарч хэлбэлздэг. Хавар 3, 4 дүгээр сард худгийн ус нэлээд багасаж, 6, 7 дугаар сард бороо орохоор нэмэгддэг. Оюу Толгой компанийнхан малчидтай хамтраад 2011 оны 6 дугаар сараас худгийн усанд хамтарсан хяналт хийж байна. Малчид өөрсдөө худгийн усныхаа түвшинг хэмжээд, чанарт нь хяналт хийж, тэмдэглэл хөтөлж, үүнийгээ Оюу Толгойн ажилчдынхтай тулгаж үздэг. Одоогоор ямар нэг зөрүү гарахгүй байгаа тухай тус компанийн цахим мэдээллийн хуудсанд тэмдэглэсэн байна.

3.5 Геологийн тогтоц

Төслийн талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутагт, Монгол улс ба БНХАУ-ын хил дээр орших Гашуунсухайтын хилийн боомтын дэргэд буюу Говийн бага дархан газрын "Б" хэсгийн баруун өмнөд захад байрлана.

Геологийн тогтцын хувьд талбайн бүх хэсэгт делювийн гаралтай шаварлаг чигжээстэй хайр, хайрга, элсэрхэг, шаварлаг хурдас ээлж дараалан үелэн тогтсон ба түүний доор палеозой, мезозойн настай гранит, граносиенит, диорит, гранодиорит зэрэг интрузив чулуулгийн массив голлон оршино. Дөрөвдөгч орчин үеийн сэвсгэр хурдасны зузаан нь талбайн хэмжээнд хөндийн хотос газраа 30-35 м, дэнж газартаа 10-15 м хүрнэ.

Энэ нутаг нь Монгол орны зүүн өмнө хэсгийн цөлөрхөг хээрийн нугын хужирлаг, мараалаг, карбонатлаг цайвар бор болон цөлөрхөг хээрийн хөрс бүхий заримдаг цөл ба цөлийн хөрстэй, геоморфологийн мужлалаар Африк-Азийн цөлийн мужийн Галбын говийн дэд мужид багтана.

Төслийн талбайн газрын гадарга ерөнхийдөө тэгш боловч бэсрэг хотгор гүдгэрийн ялгаатай.

3.6 Хөрсөн бүрхэвч

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цагаан хадны Гаалийн хяналтын талбайн ерөнхий газрын өндөр далайн төвшнөөс дээш 900–1100 метрийн хооронд хэлбэлзэнэ. Талбай орчим нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Говийн их мужийн өргөргийн бүсшилийн цөлийн бор саарал хөрсний 14-р тойрогт хамрагдана.

Талбайн орчмын нутагт тархсан хөрсийг ялгаж тогтооход Сайрын болон цөлийн бор тархсан байна. Талбайгаас авсан дээжүүдэд хүнд металл болон эрүүл ахуйн шинжилгээг “НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК-ийн хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.

Шинжлүүлсэн элементүүдийн хувьд “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” (MNS 5850:2019)-ийн стандартын хүлцэх агууламжийг давсан үзүүлэлт илрээгүй.

3.7 Ургамлан бүрхэвч

Төслийн талбай нь нам уулс хоорондын тэгш хөндийд байрлах бөгөөд цөлийн хээрийн сайрын хялгана- ахарнавтит баглуурт бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 28%, 21 зүйлийн ургамалтай (бичиглэл-1), ургац 1,6 ц/га. Ургамлан нөмрөгийн өндөр 5-70 см бөгөөд 3 ярус үүсгэнэ. Эхлээд хотирын ярус 40-70 хүртэл см, заримдаг сөөгөнцрүүдийн ярус 20-40 см, баглуур өвслөг ургамлын ярус 5-15 см. Мөн өмнө жил хур бороо их байсантай холбоотойгоор цөөн наст ургамлын хагд хадгалагдан үлдсэн. Зонхилогч ургамлын хувьд үетнээс сайрын хялгана, алаг өвснөөс, таана, багдай, аммоний сэдэргэнэ, цөөн наст ургамлаас бага хургалж ургана. Сөөгнөөс баглуур (1м² талбайд 7-10ш, диаметр 3-8см), боролз, хармаг, орог тэсэг тохиолдоно. БОНХАЖЯ-ны 2015 оны 282 дугаар сайдын тушаалаар батлагдсан Ашигт ургамлын жагсаалтад нэн ховор тархалттай 1 зүйл (Limonium aureum – алтан бэрээмэг), ховор тархалттай 1 зүйл (Oxytropis aciphylla-өргөст ортууз), элбэг тархалттай (Convolvulus ammanii-Аммоний сэдэргэнэ, Allium polyrrhizum-Таана, Astragalus galacitities- шүдэн цагаан хунчир, Asparagus gobicus- хэрээн нүд) ургамал ургана. Бэлчээрийн талхагдал бага.

3.8 Тусгай хамгаалалттай газар нутаг

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орон нутгийн тусгай хамгаалалттай буюу аймгийн тусгай хамгаалалтад 2, сумын тусгай хамгаалалтад авсан 25 газар байдаг. Гаалийн хяналтын бүс нь аймгийн тусгай хамгаалалттай Аймгийн урд талын сумдын улсын хил дагуух газарт байрлаж байна.

3.9 Түүх соёл, археологийн дурсгалт зүйлс

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан уг жагсаалтад 175 дурсгалыг улсын хамгаалалтад, 275 дурсгалыг аймгийн хамгаалалтад авахаар оруулсан байна. Өмнөговь аймгийн Ханбогд суманд Улсын тусгай хамгаалалтад авсан дараах түүх дурсгалын газрууд байна.

- Байшин цав, Хуурай цав, Үрэлбэ, Амтгайн палеонтологийн дурсгалт газрууд
- Галбын гурван хийд буюу Дэмчигийн хийд, Эрээт хийд, Цогцолын хийдийн туурь
- Жавхлант Хайрхан, Далайн дуулга, Зүүн хацавч, Цагаан толгой, Шийрийн хадны зургууд

Төслийн талбай болон ойр орчмын бүс нь олон жилийн туршид бэлчээрийн зориулалтаар ашиглагдаж байсан бөгөөд гаалийн хяналтын талбай үйл ажиллагаа явуулснаас хойш түүх соёлын дурсгалт зүйл олдсон тухай тэмдэглэл одоогоор байхгүй байна.

3.10 Нийгэм, эдийн засаг

Өмнөговь аймаг нь 2023 оны байдлаар нийт 76,153 хүн бүртгэгдсэнээс Ханбогд суманд 8941 хүн, Хайрхан багт 640 хүн бүртгэгдсэн байна. Тус сум нь Монгол улсын өмнөд хилээс 138 км, аймгийн төвөөс 295 км, нийслэл Улаанбаатар хотоос 779 км-т алслагдсан бөгөөд өмнө талаараа БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Баяннуур аймагтай,

баруун талаараа Баян-Овоо, хойд талаараа Манлай, зүүн талаараа Дорноговь аймгийн Хатанбулаг, Мандах сумтай тус тус хил залгана.

Хүснэгт № 2. 2023 оны хүн амын тоо

Үзүүлэлт	Өмнөговь аймаг	Ханбогд сум	Хайрхан баг
Хүн амын тоо	76,153	8,941	640
Эрэгтэй	38,903	5,304	456
Эмэгтэй	37,250	3,637	184
Өрхийн тоо	25,336	2,193	138

Өмнөговь аймаг нь 2023 оны байдлаар 2042 мян. тоо толгой мал тоологдсоноос Ханбогд суманд 164.18, Хайрхан багт 0.97 мян толгой мал тоологдсон байна.

Хүснэгт № 3. 2023 оны мал тоо /мян.толгой/

Аймаг, сум	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Өмнөговь	2,042	92.75	27.57	157.18	547.3	1,217.21
Ханбогд сум	164.18	9.11	6.19	33.25	45.67	69.96
Хайрхан баг	0.97	-	0.06	0.02	0.36	0.53

4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

ISO 14001:2016 байгаль орчны удирлагын тогтолцооны стандартын дагуу компанийн зүгээс байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор байгаль орчны асуудлууд тэдгээрээс улбаатай байгаль орчны нөлөөллүүдийг тодорхойлж эрсдэлийн үнэлгээ хийсэн. Эрсдэлийн үнэлгээ нь байгаль орчны гол асуудлыг зөв таньж тодорхойлоход дөхөм болсноор компани байгаль орчны чиглэлээр хийх ажлын ач холбогдлын эрэмбэ дарааллыг тодорхойлон гаргав.

4.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц

ISO 14001:2016 стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийсэн. Байгаль орчны асуудлыг тодорхойлж эдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлсон. Нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон

Хүснэгт № 4. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				
	Ялимгүй	Бага	Дунд	Их	Гамшиг
I бараг болохгүй	L	L	M	H	H
II магад болохгүй	L	L	M	H	E
III болзошгүй	L	M	H	E	E
IV магад болох	M	H	H	E	E
V лавтай болох	H	H	E	E	E

Хүснэгт № 5. Магадлалын үнэлгээний шалгуур

Түвшин	Зэрэг	Тайлбар
I	Бараг болохгүй	Онцгой нөхцөлд эрсдэлтэй байж магадгүй (<5%)
II	Болохгүй байж магад	Заримдаа эрсдэлтэй байж магадгүй (5-20%)
III	Болзошгүй	Заримдаа эрсдэл үүснэ (20-50%)
IV	Магад болох	Бараг бүх нөхцөл эрсдэл үүсгэж болзошгүй (50-70%)
V	Лавтай болох	Бараг бүх нөхцөл эрсдэлтэй (70-100%)

Хүснэгт № 6. Үр дагаварын үнэлгээний шалгуур

Зэрэглэл	Уршиг	Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт		Уршгийг бууруулах арилгах шийдэл
		Хүн ам	Эд хөрөнгө	
I	Ялимгүй	Техноген нөлөө арилахад хор уршиг арилна	Хохирол үгүй	Тусгай шийдэл шаардлагагүй

II	Бага	Бүс нутагт хуримтлагдах нөлөөлөл бий болгож био орчинд стресс учруулна	Багавтар хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн горимыг мөрдөх
III	Дунд	Урт хугацаанд дэлхийн дулааралд хувь нэмэр оруулна	Дунд зэрэг хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн чанд горимыг мөрдөх, зохион байгуулалтын өндөр түвшинд ажиллах
IV	Их	Хуримтлагдах сөрөг нөлөө үүсгэж урт хугацаанд экологийн тэнцвэр алдагдана	Их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил, Тодорхой хэмжээний хөрөнгө зардал шаардана
V	Гамшиг	Байгаль орчинд эргэж буцахааргүй уршиг учруулж экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ	Маш их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил. Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана

Хүснэгт № 7. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон үйл ажиллагаатай холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт

№	Байгаль орчны асуудлууд	Нөлөөллийн үр дагавар			
		Нөлөөлөхгүй	Бага	Дунд	Их
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал					
1	Голын гольдролыг эвдэж, өөрчлөх	x			
2	Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	x			
3	Үерийн аюулд өртөх		x		
4	Түүх, соёлын дурсгалт газар, археологи-палеонтологийн олдворт газрыг эвдрэхэд хүрэх	x			
5	Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажилагаатай зөрчилдөх	x			
6	Булаг, шандын усны горимд өөрчлөлт орох ба хатах, ширгэж үгүй болох аюултай эсэх	x			
2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал					
7	Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, нүүрс ачиж буулгах, хадгалах болон орчны бохирдлын хяналтад сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой		x		
8	Осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			x	
9	Үйл ажиллагааны үеийн үерийн хамгаалалтын асуудал хир нийцтэй тусгагдсан, үр ашигтай ажиллах явдал хир зэрэг зохимжтой			x	
10	Төсөл хэрэгжүүлэх үед хорт бодис, нэгдлээс хамгаалах асуудал хир нийцтэй тусгагдсан, үр ашигтай ажиллах явдал хир зэрэг зохимжтой	x			
11	Ус хэрэглэх, усны чанарыг хамгаалах, хянах асуудал			x	
12	Ус, агаар, хөрс бохирдох, хатуу хог хаягдал болон дуу чимээ гарах			x	
13	Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх		x		
14	Төслийн үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		x		
3. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал					

15	Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх				x
16	Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			x	
17	Хөрсний эвдрэл элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)		x		
18	Эрдэс баялгийг авч ашиглах зэргээс шалтгаалж хөрсөнд ус нэвчих, гүний ус бохирдох, улмаар хөрсний усны горимд эсрэгээр нөлөөлөх	x			
19	Газар ашиглалтад хохирол учруулах, үйл ажиллагаа явуулах үед газар тэгшлэх, буцааж булах ажлыг хамгийн бага байлгах нь бусад зорилгод ашигтай байж болох, хөрш зэргэлдээх газар ашиглалтад гэмтэл учруулахгүй байх зэрэг асуудал төсөлд тусгагдсан эсэх		x		
20	Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		x		
21	Төслийн талбайг өөр зориулалтаар ашиглах боломжийг авч үзсэн эсэх	x			
22	Төслийг хэрэгжүүлэх үеийн инженерийн болон санхүүгийн боломжийн талаарх асуудал				x
4. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)					
23	Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад нөөц баялгийг ашиглах боломжийг ашиглахгүй орхигдуулах	x			
24	Төслийн техник технологийн шийдлийг техник, эдийн засгийн хувьд олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал		x		
Нөлөөллийн үнэлгээний тоон утгын хувь		36%	32%	24%	8%

Хүснэгт № 8. Төслийн байгаль орчны болзошгүй нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

Нөлөөллийн төрөл	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нийт оноо	Онооны эзлэх хувь %	Нөлөөллийн зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт							
Усны чанарын өөрчлөлт	2	3	1	2	8	32	Дунд
Ургамлын бүтцийн өөрчлөлт	3	5	1	4	13	52	Дунд
Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол	2	5	1	3	11	44	Дунд
Геологийн тогтцын өөрчлөлт	2	5	1	5	11	44	Дунд
Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт	1	5	1	2	7	28	Бага
Агаарын орчин /бохирдол/	8	5	1	4	18	72	Дунд
Газар доорх усны нөөц	6	4	2	3	15	60	Дунд
Дундаж						46.2	Дунд
2. Байгалийн нөөцийн ашиглалт							
Газрын гадаргын нөөц баялаг	1	5	1	1	8	36	Дунд
Бэлчээр, тэжээлийн байдал	2	5	1	1	6	24	Бага
Эрдэс түүхий эдийн нөөц	6	5	2	2	15	60	Дунд
Дундаж						38.67	Дунд
3. Байгаль орчны чанар, нийгмийн өөрчлөлт							
Ундны усны чанар, хэмжээ	4	4	1	2	11	44	Дунд
Хөрсний бохирдол	2	3	1	2	8	32	Дунд
Агаарын чанар	8	5	1	4	16	64	Дунд
Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	2	5	1	2	10	40	Дунд
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+						+
Орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлөх	+						+
Дундаж						30.0	Бага
4. Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, соёлт давхаргад үзүүлэх нөлөөлөл							
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	-	-	-	-	-	-	-
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	-	-	-	-	-	-	-
Тусгай хамгаалалтай ба цогцолбор газарт нөлөөлөх	-	-	-	-	-	-	-

Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	4	4	1	3	12	48	Дунд
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	6	4	1	4	15	60	Дунд
Дундаж						21.6	Бага
5. Бусад нөлөөлөл							
Тээвэрлэлтээс шалтгаалан хөрс эвдрэх	2	2	1	2	7	28	Бага
Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих	2	1	1	2	6	24	Бага
Хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга	2	1	1	2	6	24	Бага
Дундаж						25.3	Бага
Үр дүн (ерөнхий дундаж)						29.45	Бага

4.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь гаалийн хяналтын талбай байршиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Тиймээс төслийн үйл ажиллагааны явцад үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитойгоор төлөвлөсөн БОМТ-г төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлөө бүрдүүлэх нь энэхүү төлөвлөгөөний үндсэн зорилго болно.

БОМТ үндсэн зорилгоо хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхын хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах бодлогыг баримтална. Үүнд:

- БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдуулах;
- БОМТ-ний хэрэгжилтийг компанийн удирдлага өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
- БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр гаалийн хяналтын талбайг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах зэрэг нөхцөлүүдийг тодорхойлно.

4.3 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ

БОМТ нь “Эрдэнэс гаалийн хяналтын талбай” төслийн үйл ажиллагааны хэмжээнд дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтын дагуу хэрэгжих бөгөөд БОННУ-ний тайлангийн 1 дүгээр бүлэгт төслийн хамрах хүрээг тодорхойлсон. Төслийн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны явцад хүрээлэн буй орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилт бүхий энэ төлөвлөгөөнд БОННУ-ний тайланд тусгасан зөвлөмжүүдийн хүрээн дэх бүхий л асуудлыг хамрахад БОМТ нь дараах үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ):
- Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа орчны болон ажлын байрны нөхцөлийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ):

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах эрх зүйн баримт бичиг болон шаардлагыг нь зайлшгүй хангаж мөрдөх стандартуудыг БОМТ-нд тодорхой тусгаж өгнө.

Тухайн жилийн БОМТ боловсруулах, биелэлтийг тайлагнах журамд зааснаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах агуулгатай байх бөгөөд хийх ажлын зардлыг тус бүрчлэн тооцож төлөвлөнө. Үүнд:

- Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан төлөвлөгөө;
- Орчны тохижилт, өргөтгөлийн дараах нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө;
- Төслийн талбай орчмын түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;
- Үйл ажиллагааны үеийн осол, эрсдэлийн менежмент;
- Үйл ажиллагааны үеийн хог хаягдлын менежмент;
- Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ;
- Тухайн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөлт;
- БОМТ-г нөлөөллийн бүсийн олон нийт, оршин суугчдад тайлагнах, хэлэлцүүлэх арга хэмжээний төлөвлөлт;

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр


№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
5.1.1	Машин техникүүдийн янданд шүүлтүүр суурилуулж, найдвартай ажиллагааг хангах, ялгаруулж буй хорт хийн түвшинд хяналт тавих болон янданд оч баригч хийх	Жилийн турш	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эзэмшлийн 19 техникийн янданд шүүлтүүр, оч баригч суурилуулж, найдвартай ажиллагааг хангах, техник бүрийн хэвийн ажиллагааг 7 хоног бүр тогтмол хянаж ажилладаг.	100%
5.1.2	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг, шалгалтад тогтмол оруулж, засвар үйлчилгээг тогтмол чанартай хийх	Жилийн турш	Төслийн үйл ажиллагаанд ашигладаг хөнгөн тээврийн хэрэгслүүдэд засвар үйлчилгээг хуваарийн дагуу тогтмол хийж, үзлэг, шалгалт, үйлчилгээ хийгдсэн тухай хуудсыг бөглөн ажилладаг. Компанийн эзэмшлийн техник хэрэгслүүдийг нэгдсэн журмаар улсын үзлэг оношилгоонд жил бүр хамруулдаг.	100%
5.1.3	Хуурай хог хаягдлыг хогийн цэгт зайлуулахгүйгээр шатаахыг хориглох	Жилийн турш	Хуурай хог хаягдлын цэвэрлэгээг дотооддоо 7 хоног бүр хийж тодорхой цэгт бөөгнүүлдэг ба катерингийн компани тухай бүр ачиж зайлуулдаг. Хог хаягдлыг шатааж устгадаггүй. Энгийн хог хаягдал сард дунджаар 7 тонн гардаг ба катерингийн компани зохих цэг рүү тээвэрлэж хаядаг.	100%
5.1.4	Талбайн тоосжилтыг дарах зорилгоор байнгын усалгаа хийх /Усалгааны машинтай болох/	Жилийн турш	Компани нь өөрийн эзэмшлийн 1 ш, түрээсийн 1 ш усны машиныг тус тус ашиглаж байна. Хоногт 35 тн машинаар 2 удаа усалгаа хийж байна.	100%

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
5.1.5	Тоосжилтыг бууруулах зорилгоор нүүрс ачиж буулгах талбайд 1600 м урт 8 м өндөр хашааг барьж байгуулсан байгаа ба эвдрэл гарсан үед тогтмол засварлах	Жилийн турш	Цагаанхад нь салхи шуурга ихтэй байдаг тул тоосжилтыг бууруулах зориулалттай салхины хаалт нурах, гэмтэх, эвдрэх зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалдаг. Иймд тухай бүр салхины хаалтыг нөхөх засварлах ажлыг хийж гүйцэтгэж байна. Тайлант онд 400 ширхэг салхины торон хаалт, 722 ширхэг турбаг ашиглан 1600 м талбайд нөхөх засварлах ажил хийгдсэн.	100%
5.1.6	Нүүрсний тээврийн замаас талбай хүртэлх замыг сайжруулан хучилт хийх	Жилийн турш	Нүүрс ачилт буулгалтын талбай нь задгай нүүрс хүлээн авдаггүй бөгөөд зөвхөн чингэлэгтэй нүүрс хүлээн авч экспортод гаргадаг тул чингэлэг буулгах өргөх тохиолдолд зам цөмрөх, эвдрэх эрсдэл гардаг. Иймд зам талбайн сайжруулалт хийх зорилгоор тухай бүр шороогоор хучилт хийж талбайг индүүдэн тэгшилдэг. Цаашид талбайн хучилтыг сайжруулах зорилгоор хайрган хучилт, суурийн үеийг 98%-иас доошгүй нягтруулах, далан буюу ердийн дүүргэлтийг 95%-иас доошгүй нягтруулахаар газар шорооны хучилт хийх нарийвчилсан зураг төсөл хийж нээлттэй тендер шалгаруулалтаар гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна.	100%
5.1.7	Нүүрс ачиж буулгах хэсгийн орц гарцыг хайргаар хучих	Жилийн турш	Нүүрс ачиж буулгах хэсгийн орц, гарцын 0.7 га талбайг гэрээгээр гаалийн хяналтын талбайг ашиглагч компаниар шороо дэвсүүлэх ажлыг тогтмол хугацаанд хийж байна.	100%

5.1.1 Машин техникүүдийн янданд шүүлтүүр суурилуулж, найдвартай ажиллагааг хангах, ялгаруулж буй хорт хийн түвшинд хяналт тавих болон янданд оч баригч хийх

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эзэмшлийн 19 техникийн янданд шүүлтүүр, оч баригч суурилуулж, найдвартай ажиллагааг хангах, техник бүрийн хэвийн ажиллагааг 7 хоног бүр тогтмол хянаж ажилладаг.





Зураг 4. Машин техникүүдийн янданд шүүлтүүр болон янданд оч баригч суурилүүлагдсан байдал

5.1.2 Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг, шалгалтад тогтмол оруулж, засвар үйлчилгээг тогтмол чанартай хийх

Төслийн үйл ажиллагаанд ашигладаг хөнгөн тээврийн хэрэгслүүдэд засвар үйлчилгээг хуваарийн дагуу тогтмол хийж, үзлэг, шалгалт, үйлчилгээ хийгдсэн тухай хуудсыг бөглөн ажилладаг. Компанийн эзэмшлийн техник хэрэгслүүдийг нэгдсэн журмаар улсын үзлэг оношилгоонд жил бүр хамруулдаг.

ТЭХНИК ТОНГО ТӨГӨРӨМДИЙ УЗЛАГ ХИЙХ ЗААВАР		ТЕХНИК, ТОНГО ТӨГӨРӨМДИЙ УЗЛАГ ХИЙХ ЗААВАР	
ТЕХНИК УЗЛЭГИЙН ХҮҮДАС "Хөнгөн тэргэл"			
Модель	LAND	Активный дугаар	4084-447
Парк дугаар	148/1	Хувиараа үзэгч	1475
Утгаар эхлэхийн цаг:	00:50	Утгаар дууссаны цаг	00:50
		Эрх баригч	Шонё
НӨХЦӨН БАЙДЛЫН ТУШАЛ			
ok	Хэвийн		
A	Даварлын хуваарыг утгаар төлөөлөгөөд үйлчилгээг тургал ажиллаж болно		
N	Шувд засварласан эсвэл харгалзахгүй		
ok	Хувиараа үзэгч	Хяналтын үзэгч	
Y	Утгаар эхлэхийн цаг	Нэмэлт тайлбар	
№	Утгаар эхлэхийн цаг	ok	A
1	Хадгалгуурийн хөрлөрт, гоошилт	✓	
2	Агаарын орох хоолой	✓	
3	Дарлагын тар, бэлэнгээ	✓	
4	Хадгалгуурийн системийн холбоотуу (гоомит) хамгийн чанга, сур, лартууба шоронт, сонгий гадна хамгаалт /м/	✓	
5	Ремень, ремнь дамжуулга (АС, эмс, жанам)	✓	
6	Гаднын шингэний түвшин, бохирдол	✓	
7	Тормозны шингэний түвшин, бохирдол	✓	
8	Хадгалгуурийн тосны түвшин, бохирдол	✓	
9	Хэрчилтийн шингэний түвшин, Концентрацын хурь	✓	
10	Каскар, хүйсийн боолт	✓	
11	Хадгалгуурийн палира резин шалта	✓	
12	Урд, хойд дугуйн худалгевтай эсхийн шалта	✓	
13	Урд, хойд дугуйн тоо соогийтой эсхийн шалта	✓	
14	Урд ступеньча хангалгаа хийний эсхийн шалта	✓	
15	Уулын алпарат шалта	✓	
16	Уулын авиаторатор, шайрш шалта	✓	
17	Урд хөндлөн татуургайн бутлага	✓	
18	Тэмээн гарны атулга шалта	✓	
19	Урд танхилгайн туга шалта	✓	
20	Урд танхилгайн шалдаг шайрш шалта (Тоогоог хийх)	✓	
21	Урд, хойд хэвтээ танцүүлчийн дарвин резин шалта	✓	
22	Урд, хойд Босоо танцүүлчин шалта	✓	
23	Урд, хойд авиаторатор шалта (тоо гоомжит, гуламжит, атулга, тавга, суурь - м)	✓	
24	Ташийн либра резин шалта	✓	
25	Нум, нумын атулга, пальц, стермень, центрийн боолт шалта	✓	
26	Урд, хойд танхилгайн дутуун шилжа, чаналгаа шалта	✓	
27	Урд, 1-2 байрлалын дутуун намда, флажны энгэлдэг шалта (10000 км тутамд) (тормоны авларот, лощинжийн ажиллагаа шалта)	✓	
28	Хойд, 3-4 байрлалын дутуун намдажны энгэлдэг шалта (15000 км тутамд), тормоны авларот, талзлагчийн ажиллагаа шалта)	✓	
29	Дугуйн хийн дарвалт шалта	✓	
30	Дугуйн хэмжээ энгэлдэг шалта	✓	

Техник, тогтог төхөөрөмж зэвсэр, үйлчилгээний хийх журим, гуравдугаар хавсраа

Засвар үйлчилгээний ажлын хуудас /Түр/

Ажлын бүтэц ажил	Ажлын дугаар	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Нийт дүгээр	Хүндийн	Мөнгө	Хүндийн
Ажлын бүтэц ажил	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн	Мөнгө	Хүндийн
Засвар үйлчилгээний ажлын хуудас							

1624.10.1
 1624.10.1
 1624.10.1

- Үйлчилгээний хийх

Засвар үйлчилгээний төрөл

Төлөөлөгчтэй засвар	Төлөөлөгчтэй бус засвар
☐ Хөдөлгөөн ☐ Гадаргуу ☐ Агаарын систем ☐ Цахилгаан систем ☐ Тослогын систем ☐ Төрөлтийн систем	☐ Хөдөлгөөн ☐ Гадаргуу ☐ Агаарын систем ☐ Цахилгаан систем ☐ Тослогын систем ☐ Төрөлтийн систем

1624.10.1
 1624.10.1
 1624.10.1


Засвар үйлчилгээний ажлын хуудас

№	ID	Ажлын бүтэц ажил	Ажлын дугаар	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Нийт дүгээр	Хүндийн
1		Хөдөлгөөн	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
2		Гадаргуу	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
3		Агаарын систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
4		Цахилгаан систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
5		Тослогын систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
6		Төрөлтийн систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
7		Хөдөлгөөн	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
8		Гадаргуу	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
9		Агаарын систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
10		Цахилгаан систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
11		Тослогын систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
12		Төрөлтийн систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
13		Хөдөлгөөн	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
14		Гадаргуу	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
15		Агаарын систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
16		Цахилгаан систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
17		Тослогын систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
18		Төрөлтийн систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
19		Хөдөлгөөн	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
20		Гадаргуу	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
21		Агаарын систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
22		Цахилгаан систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
23		Тослогын систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
24		Төрөлтийн систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
25		Хөдөлгөөн	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
26		Гадаргуу	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
27		Агаарын систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
28		Цахилгаан систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
29		Тослогын систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн
30		Төрөлтийн систем	418410.1	Төрөлтийн нэгдэл	Хүндийн	Хүндийн	Хүндийн

Зураг 5. Засвар үйлчилгээг хуваарийн дагуу тогтмол хийж, үзлэг, шалгалт, үйлчилгээг хийгддэг байдал

5.1.3 Хуурай хог хаягдлыг хогийн цэгт зайлуулахгүйгээр шатаахыг хориглох

Хуурай хог хаягдлын цэвэрлэгээг дотооддоо 7 хоног бүр хийж тодорхой цэгт бөөгнүүлдэг ба катерингийн компани тухай бүр ачиж зайлуулдаг. Хог хаягдлыг шатааж устгадаггүй. Энгийн хог хаягдал сард дунджаар 7 тонн гардаг ба жилийн хугацаанд 84 тн орчим хог хаягдлыг цэвэрлэж зохих цэг рүү тээвэрлэж хаясан.



Зураг 6. Хог хаягдлыг хогын түр цэгт төвлөрүүлэн хадгалж хог хаягдлын цэгт хүргэж буй байдал

5.1.4 Талбайн тоосжилтыг дарах зорилгоор байнгын усалгаа хийх /Усалгааны машинтай болох/

“Эрдэнэс гаалийн хяналтын талбай” нь 2024 оны 06-р сар хүртэл үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд 6-р сараас биржийн нүүрс тээвэрлэж буй компани уг талбайг ашиглан гаалийн бүрдүүлэлт хийж эхэлсэн. Компани нь өөрийн эзэмшлийн 1 ш усны машинтай ба терминалын талбайн усалгааг хийдэг. Дулааны улиралд тоосжилтоос сэргийлж 35 тн усалгааны машинаар хоногт 2 удаа усалгаа хийдэг.

Харин НАБТ-н зам усалгааг түрээсийн усны машинаар услуулдаг ба 2024.04.27-ны өдөр байгуулсан “Техник түрээсээр ажиллуулах гэрээ”-г хавсаргав.



Зураг 7. Түрэсийн усны машинаар зам талбайн тоосжилт дарах усалгаа хийж буй байдал

5.1.5 Тоосжилтыг бууруулах зорилгоор нүүрс ачиж буулгах талбайд 1600 м урт 8 м өндөр хашааг барьж байгуулсан байгаа ба эвдрэл гарсан үед тогтмол засварлах

Цагаанхад нь салхи шуурга ихтэй байдаг тул тоосжилтыг бууруулах зориулалттай салхины хаалт нурах, гэмтэх, эвдрэх зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалдаг. 2024 онд 400 ширхэг салхины торон хаалт, 722 ширхэг трубаг ашиглан 1600 м талбайд салхины хаалтыг нөхөх, засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 8. Салхины хаалтыг сэргээн засварласан байдал

5.1.6 Нүүрсний тээврийн замаас талбай хүртэлх замыг сайжруулан хучилт хийх

Нүүрс ачилт буулгалтын талбай нь задгай нүүрс хүлээн авдаггүй бөгөөд зөвхөн чингэлэгтэй нүүрс хүлээн авч экспортод гаргадаг тул чингэлэг буулгах өргөх тохиолдолд зам цөмрөх, эвдрэх гардаг. Иймд зам талбайн сайжруулалт хийх зорилгоор тухай бүр шороогоор хучилт хийж талбайг индүүдэн тэгшлэн ажилладаг.

Цаашид талбайн хучилтыг сайжруулах зорилгоор хайрган хучилт, суурийн үеийг 98%-иас доошгүй нягтруулах, далан буюу ердийн дүүргэлтийг 95%-иас доошгүй нягтруулахаар


газар шорооны хучилт хийх нарийвчилсан зураг төсөл хийж нээлттэй тендер шалгаруулалт зарлаж гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна.

Нээлт хийх огноо
2024-10-24 10:30

Хүлээн авах огноо
2024-10-24 10:00

Үлдсэн хугацаа
Дууссан

Захиалагч:
ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ

Вэб сайт:


ИХИЛ ТӨСТЭЙ УРИЛГА

Чингэлэг тээврийн терминалын өргөтгөл, гаалийн хяналтын бүсийн талбайн хучилт, бетон талбайн ажил ➔ ҮР ДҮН ХАРАХ

ЗАХИАЛАГЧ:	Эрдэнэс Таван Толгой
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨРӨЛ:	Ажил
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:	ЭТТХК/20240101017
УРИЛГЫН ДУГААР:	ЭТТХК/20240101017/01/01
САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР:	Өөрийн хөрөнгө
НИЙТ ТӨСВӨТ ӨРТӨГ:	8,372,919,818 ₮
ТУХАЙН ОНД САНХҮҮЖИХ ТӨСВӨТ ӨРТӨГ:	8,372,919,818 ₮
ХАА-НЫ МӨРДӨХ ЖУРАМ:	Нээлттэй тендер шалгаруулалтын арга
ЦАХИМ ТЕНДЕР ЭСЭХ:	Халбаршуулсан цахим
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ТӨЛӨВ:	Нэгдсэн

Огноо: **2024-09-25**
Тендер шалгаруулалтын нэр: Чингэлэг тээврийн терминалын өргөтгөл, гаалийн хяналтын бүсийн талбайн хучилт, бетон талбайн ажил
Тендер шалгаруулалтын дугаар: ЭТТХК/20240101017

- Эрдэнэс Таван Толгой нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ:
 - > 1 "Гашуунсухайт боомт дахь чингэлэг тээврийн терминалын өргөтгөл"
 - > 2 "Эрдэнэс" гаалийн хяналтын бүсийн чингэлэг ачих, буулгах нүүрс ачилт, буулгалтын талбайг байгуулах"
- Тендерийг **2024 оны 10-р сарын 24-ны өдрийн 10 цаг 00 минут**–аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 10-р сарын 24-ны өдрийн 10 цаг 30 минут**-д нээнэ.
- Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **Зөвшөөрөхгүй**
- Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **Эрхгүй**
- Тендер нь түүнийг нээнснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
- Тендерийн баталгаа шаардах эсэх: **33,003,800** төгрөг. Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн дүн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
- Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **Үгүй**
- Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **Үгүй**
- Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалтын баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд үйлчилгээний хураамж төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй байна.

Монгол, Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8 Финанс төв, "Эрдэнэс Тавантолгой" ХК,
7505-5555 /503-510, 501/


Нээлт хийх огноо
2024-12-20 10:30

Хүлээн авах огноо
2024-12-20 10:00

Үлдсэн хугацаа
Дууссан

Захиалагч:
ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ

Вэб сайт:



ИЖИЛ ТӨСТЭЙ УРИЛГА

Чингэлэг тээврийн терминалын өргөтгөл, гаалийн хяналтын бүсийн талбайн хүчилт, бетон талбайн ажил УР ДҮН ХАРАХ

ЗАХИАЛАГЧ:	Эрдэнэс Таван Толгой
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨРӨЛ:	Ажил
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:	ЭТТХК/20240101017
УРИЛГЫН ДУГААР:	ЭТТХК/20240101017/02/01
САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР:	Өөрийн хөрөнгө
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:	8,372,919,818 ₮
ТУХАЙН ОНД САНХҮҮЖИХ ТӨСӨВТ ӨРТӨГ:	8,372,919,818 ₮
ХАА-НЫ МӨРДӨХ ЖУРАМ:	Нээлттэй тендер шалгаруулалтын арга
ЦАХИМ ТЕНДЕР ЭСЭХ:	Халбаршуулсан цахим
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ТӨЛӨВ:	Үр дүн гарсан

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: 2024-11-28
Тендер шалгаруулалтын нэр: Чингэлэг тээврийн терминалын өргөтгөл, гаалийн хяналтын бүсийн талбайн хүчилт, бетон талбайн ажил
Тендер шалгаруулалтын дугаар: ЭТТХК/20240101017

1. Эрдэнэс Таван Толгой нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ:
 - > 1 "Гашуунсухайт боомт дахь чингэлэг тээврийн терминалын өргөтгөл"
 - > 2 "Эрдэнэс" гаалийн хяналтын бүсийн чингэлэг ачиж, буулгах нүүрс ажилт, буулгалтын талбайг байгуулах"
3. Тендерийг 2024 оны 12-р сарын 20-ны өдрийн 10 цаг 00 минут-аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг 2024 оны 12-р сарын 20-ны өдрийн 10 цаг 30 минут-д нэнээ.
4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **Зөвшөөрөхгүй**
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **Эрхгүй**
6. Тендер нь түүнийг нэсэнээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
7. Тендерийн баталгаа шаардах эсэх: 33,003,800 төгрөг. Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн дүн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **Үгүй**
9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **Үгүй**
10. Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалтын баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд үйлчилгээний хураамж төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй байна.

Монгол, Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8 Финанс төв, "Эрдэнэс Тавантолгой" ХК,
7505-5555 /503-510, 501/

Зураг 9. Тендер шалгаруулалт зарласан байдал

Хэдийгээр тендер шалгаруулалтын ажил удаашралтай байгаа боловч гаалийн хяналтын талбайг гэрээгээр ашиглаж буй компаниар нүүрс тээврийн замаас гаалийн хяналтын талбай хүртэлх замын арчилгаа, хучилтын ажлыг тогтмол хийлгэж байна.



Зураг 10. Хяналтын бүсийн орц, гарцад шороогоор дэвсэлт хийж сайжруулж буй ажлын зураг

5.1.7 Нүүрс ачиж буулгах хэсгийн орц гарцыг хайргаар хучих

Нүүрс ачиж, буулгах хэсгийн орц гарцын 0.7 га талбайг гаалийн хяналтын талбайг гэрээгээр ашиглаж буй компаниар шороо дэвсүүлэх ажлыг тогтмол хугацаанд хийж байна.



Зураг 11. Гаалийн хяналтын талбайн орц, гарц болон
